

## ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НУТАГТ ХАДНЫ СҮГ ЗУРГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА ХИЙСЭН ТУХАЙ

**З.БАТСАЙХАН<sup>1</sup>, РИЧАРД КОРТУМ<sup>2</sup>, Х.ЕДИЛХАН<sup>3</sup>**

<sup>1</sup>. МУИС.НШУС, Антропологи-Археологийн тэнхим

<sup>2</sup>. АНУ, Теннессиин Их Сургууль

<sup>3</sup>. Баян-Өлгий, "Алтай Тур" компани

Хадны зургийн хайгуул судалгааны экспедиц 2004 оны 5-р сарын 29-өөс 6-р сарын 12 хүртэл ажилласан бөгөөд Монголын талаас З.Батсайхан, Х.Едилхан, Ричард Кортум нар оролцлоо. Судалгааны гол зорилго нь урьд өмнө судалгааны хүрээнд ороогүй сүг зургийн шинэ дурсгалт газрыг илрүүлэн олж цаашид бүрэн хэмжээгээр үргэлжлүүлэн шинжлэн судлахад чиглэж байгаа юм.

Бид энэ удаа Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Улаанхус, Буянт зэрэг гурван сумын нутаг дахь 4 газарт энгийн болон нарийвчилсан хайгуул судалгаа зохион явуулсны үр дүнд Кайрагт (Билүүт), Харгант, Талд Булаг голын билчир, Бөөрөгт зэрэг газарт хэдэн мянгаар тоологдох сүг зурагтай дурсгалт газрыг шинээр илрүүлэн оллоо. Ялангуяа Хотон, Хурган нуурын зүүн эрэг дагуу орших Кайрагт (Билүүт) уулын урд энгэрээр байх сүг зургуудыг онцлон дурдууштай. Энд, нар салхинд түлэгдэж толигор болсон хүрэн хайрган гарцууд дээр ан гөрөөний сэдэвтэй зураг зонхилохоос гадна дайн тулаан түүнчлэн, мал аж ахуйн үүсэл хөгжилтэй холбогдох зургууд байна. Мөн 10 орчим тэрэгний зураг шинээр олдлоо.

Энэ удаагийн хайгуул судалгаагаар зарим онцгой сонирхолтой зургуудыг хэсэгчлэн болон бүтнээр нь хуулах, зургийг нь авах дурсгалт газрын тойм зураг зохиох болон гол гол цэгүүдийн солбицлыг тогтоох ажлыг хийж гүйцэтгээд цаашид бүрэн хэмжээгээр үргэлжлүүлэн судлахаар боллоо.

Жич: Экспедицийн үйлчилгээнд ажилласан Казбек захиралтай "Алтай Тур" компани, мөн дурсгалт газруудыг зааж өгсөн тус компанийн ажилтан хадны зураг сонирхон судлаач Е.Едилхан нарт гүн талархал илэрхийлье.